



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

141 /141/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.09.23

ҮЙЛ ЯВДАЛ

ДАЙЧИН НӨХӨРЛӨЛӨӨ БАТАТГАСАН 1600 АЛБА ХААГЧ ХАМТАРСАН ХЭЭРИЙН СУРГУУЛЬД ОРОЛЦОЖ БАЙНА



Монгол Улс, ОХУ-ын хамтарсан "Сэлэнгэ-2021" байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургуулийн нээлтийн ажиллагаа Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн Сургалтын төвийн районд зохион байгуулагдлаа.

Нээлтийн ёслолын ажиллагаанд Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай, ОХУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд И.К.Азизов, ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Д.Ганзориг, Дорнодын цэргийн тойргийн командлагчийн орлогч, дэслэгч генерал М.Я.Носулев,

Хуурай замын цэргийн командлагч, хошууч генерал Б.Амгаланбаатар нарын бусад албаны хүмүүс оролцсон юм.

Энэ сарын 22-оос 10 дугаар сарын 5-ны өдөр хүртэл үргэлжлэх "Сэлэнгэ-2021" сургууль нь "Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд бэлтгэх, зохион байгуулж явуулах" сэдвээр явагдах юм. Тус сургуульд Монгол-Оросын хамтарсан 1600 гаруй цэргийн алба хаагч оролцож байгаа бөгөөд Монголын талаас сургуулийн удирдагчаар Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн штабын дарга,

бригадын генерал Л.Онцгойбаяр, ОХУ-ын талаас Дорнодын цэргийн тойргийн 36 дугаар армийн командлагчийн үүрэг гүйцэтгэгч, хошууч генерал И.Б.Тимофеев нар үүрэг гүйцэтгэж байна.

Сонирхуулахад 2008 оноос "Дархан", 2010 оноос "Сэлэнгэ" нэрээр зохион байгуулагдах болсон тус сургууль нь бус нутгийн аюулгүй байдлыг хангахад хоёр улсын Зэвсэгт хүчний оролцоог нэмэгдүүлэх, цэрэг техникийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, цэргийн алба хаагчид харилцан туршлага солилцох боломжийг нэмэгдүүлдгээрээ тус

сургууль чухал ач холбогдолтойд тооцогддог. Түүнчлэн энэ удаагийн сургуульд Армийн нисэх баг 100 гаруй нисэх багийн бүрэлдэхүүн, МИ-24 загварын 8 нэгж нисдэг тэрэг оролцож байгаа бөгөөд тэд Сэлэнгэ сургуульд нисэх бүрэлдэхүүний үндсэн үүрэг нь Хуурай замын цэргийн бүлэглэлд агаарын дэмжлэг үзүүлж, удирдлагаас өгсөн байлдааны даалгаврыг богино хугацаанд гүйцэтгэх үүрэгтэй оролцож байна. Мөн Хуурай замын цэргийн нэгтгэл, ангиудаас хүч нэмэгдүүлсэн мотобуудлагын батальон оролцож байгаа юм.

Түүхэнд энэ өдөр

1970 он:

Монголын ардын армийн АНХНЫ СӨНӨӨГЧ АВИАЦИЙН ЭСКАДРИЛЬ байгуулагдав

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
13	4

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
35	23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,848.00	2,850.00
EUR	3,350.0	3,360.0
CNY	441.00	441.08
RUB	38.20	39.40
JPY	25.76	26.20
KRW	2.38	2.47

ЗУРХАЙ

2021.09.23 ПҮРЭВ ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 18/

НАМРЫН ДУНД УЛААГЧИН ТАХИА САРЫН ГУРВАН ХӨХ ХӨХ НОХОЙ ӨДӨР

Үс засуулбал:

Эд МАЛЫН ГАРЛАГАТАЙ Наран ургах, шингих: 06.40-18.49

Барилдлага:

Хотол чуулган

Шүтэн барилдлага:

Хурьцахуй

Суудал:

Төмөр

Тухайн өдөр бар, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр найз нөхдийг түшиж элдэв үйлийг түргэн бүтээх, бүтээл туурвил эхлэх, бизнес эхлэх, цар ихтэй үйлийг эхлэх, бясалгал хийх, доодсыг асран өглөг, хандив өргөх, лус тахих, хүүхэд үрчлэн авах, андгай тангаараг, гэрээ, хэлцлээ буцаахад сайн. Нүүдэл суудал хийх, хэрүүл тэмцэл хийх, цөөрөм байгуулах, хүүхэд хөлд оруулахад муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болтой. Хол газар яваар одогосод баруун урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй

"ЦУСАА БЭЛЭГЛЭЭ" АЯНД НЭГДЛЭЭ



донор"-оор өргөмжилсөн аж.

Цусаа өгөх нь хүний амь авраад зогсохгүй тухайн хандивлагчид өөрийнхөө эрүүл мэндийн байдлыг тандаж мэдэх, аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх зэрэг боломжийг бүрдүүлдэг гэдгийг ЗХЖШ-ын ЭМХ-ийн дарга, хурандаа Т.Сүхбаатар энэ үеэр онцолсон юм.

Мөн "Зэвсэгт хүчний офицер, ахлагч, хугацаат цэргийн алба хаагч, нэгтгэл, ангийн байнгын бие бүрэлдэхүүн сайн дурын үндсэн дээр жил бүр цусаа хандивладаг. Ялангуяа сүүлийн жилүүдэд идэвх, оролцоо эрс нэмэгдсэн. Өнөөдрийн бид бүхний өгсөн 300-400 грамм цус 3-4 хүний амийг аврах амин чухал бүтээгдэхүүн. Цус, цусан

бүтээгдэхүүний нөөц хомстсон энэ үед үүнийг нүдээ олсон чухал ажил гэж харж байна" гэв.

Зэвсэгт хүчний АЦК-ын Удирдлага, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн, хурандаа Д.Одсүрэн сонсогч байхаасаа 30 гаруй жил цусаа хандивласан "Хүндэт донор" аж. Тэрээр "Анхандаа найз нөхдийгөө дагаад л цусаа өгчихдөг байсан. Харин олон хүнд тустай буянтай гэдгийг нь мэдээд илүү илүү идэвхтэйгээр цусаа хандивлах болсон. Энэ бол хариу нэхдэггүй тус. Эхлээд би, дараа нь манай гэр бүлийн хүн, одоо хүү маань цусаа хандивлаж эхэлсэн. Салбарын бие бүрэлдэхүүндээ амьдрал бэлэглэх энэ аянд нэгдээрэй гэж уриалж байна" гэв.



Дэлхий дээр хоёр секунд тутамд хэн нэгэнд цусны хэрэгцээ гардаг гэсэн судалгаа бий. Таны цусыг цус багадаг, мээ засал, осол гэмтэл, төрөхийн хүндрэл, цусны өвчин, эрхтэн шилжүүлэн суулгах хагалгаа, хавдар, цус алдалтын үед ашигладаг. Хэрэв та 17-60 насны 45 кг-аас дээш жинтэй, өөрт ямар нэгэн зовуургүй бол цусны донор болох боломжтой аж.

Цар тахалтай тэмцэж буй энэ цаг үед Монгол Улсын цус, цусан бүтээгдэхүүний нөөцөд ердийн үеийнхээс хэд дахин илүү хомстол үүсээд байгаа. Тиймээс нийгмийн хариуцлагын хүрээнд ЗХЖШ болон төрлийн командлалын бие бүрэлдэхүүн "Цусаа бэлэглэж, цохилох зүрх бүхнийг аваръя" аянд нэгдлээ. Энэ жилийн хувьд Цус сэлбэлт судлалын үндэсний төвөөс ЗХЖШ-ыг "Цусны донор хамт олон", зарим офицер, ажилтныг "Хүндэт

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 278.408 +3417	ЭДГЭРСЭН 279,925 +6120	НАС БАРСАН 1043 +14
-----------------------------------	---------------------------	------------------------

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 5102 +87	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 199	ЭДГЭРСЭН 4806
-----------------------------	----------------------------	------------------

Тохиолдол Нийт: 230,840,298
Эдгэрсэн Нийт: 207,538,424
Нас барсан Нийт: 4,731,709



цахим шууданд

ЦЭРГИЙН НЭГДҮГЭЭР ЗЭРГИЙН БЭЛТГЭЛ ҮҮРЭГТНҮҮД СУРГАЛТАД ХАМРАГДАВ



Зэвсэгт хүчний 120 дугаар анги
3ХЖШ-ын даргын 2021 оны н/65 дугаар тушаалаар Баянгол дүүргийн Цэргийн штабаас ангид оногдуулан бүртгэгдсэн "Цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгт"-ний сургалтыг хөтөлбөр, төлөвлөгөөний Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн байрлалд артиллерийн бага мэргэжилтнээр давтан бэлтгэх сургалтыг амжилттай зохион байгууллаа.

Тус арга хэмжээний үеэр нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын ахлах, хурандаа Б.Мөнгөтулга, Баянгол дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, хурандаа Л.Цэрэгбаяр, ангийн захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга, дэд хурандаа Т.Батбор, захирагчийн орлогч, захиргааны удирдлагын тасгийн дарга, дэд хурандаа Г.Баярхүү нар үг хэлж төгсгөлд нь урлагийн хэсэгчилсэн тоглолтыг бүрэлдэхүүнд сонирхуулсан юм.

Цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнүүдэд хуваарийн дагуу албан тушаалтнууд хичээл сургуулалтыг явууллаа.

Үүнд, ахмад Д.Загдзүсэм "Жагсаалын үндсэн тодорхойлолт", "Химийн тухай ойлголт, амьсгал хамгаалах хэрэгслийн үүрэг", дэслэгч М.Сүхбат "салбар орон тооны зориулалт, их бууны бие анги тэдгээрийн үүрэг, зориулалт", дэд хурандаа Г.Баярхүү "Батлан хамгаалахын тухай хууль", дэслэгч М.Сүхбат "сумны бүтэц, үүрэг, ангилал, ажиллагааны зарчим марклалт, түүний тэмдэглэгээ", дэслэгч М.Сүхбат "Тэсрүүлэгчийн

бүтэц, үүрэг, ажиллагааны зарчим", тэргүүн ахлагч Б.Амартүвшин "Хүн нэг бүрийн буудлагын зэвсэглэл 7.62мм автоматын үүрэг зориулалт, бүтэц, эд ангиудын харилцан ажиллах зарчим" зэрэг хичээлийг төлөвлөгөөний дагуу зохион байгууллаа. Сургалтын төгсгөлд цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнүүдээс бататгах шалгалт авч, урлаг-спортын төвд сагсан бөмбөгийн тэмцээнийг явуулснаар өндөрлөсөн юм.

Ахмад Р. ВЕНВАТ



БҮЛГИЙН ТОМИЛГООГ ТОДОТГОВ

Зэвсэгт хүчний 326 дугаар анги

Ангийн бэлэн байдлыг хангах төлөвлөгөөний дагуу Хан-Уул дүүрэгт Гамшгийн хор уршгийг арилгах, сэргээн босгох, хүмүүнлэгийн тусламжийн ажиллагаанд дэмжлэг үзүүлэх арга хэмжээг зохион байгууллаа.

Энэ хүрээнд бүлгийн багаж хэрэгсэл, ар талын кабел хэрэгслийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах ажлыг ажиллагааны удирдлагын тасгийн бие бүрэлдэхүүн хийж гүйцэтгэсэн юм. Түүнчлэн бэлэн байдлын агуулахын тавиуруудыг сэргээн сайжруулах, хаалга, дээврийн битүүмжлэл, өнгө үзэмжийг сайжруулан томилгоот бүлгийн хувцас, аранз хэрэгслийг ариутгаж цэвэрлэх, товъёогжуулан хураах, шаардлагатай багаж хэрэгслийг ишлэх, ирлэх, өнгө үзэмжийг сэргээх, үер усны аюул ихэссэнтэй холбогдуулан авто машины дотуур хаймар ашиглан аврах цагариг шинээр хийж бэлэн байдлыг дээшлүүлээ. Мөн бүлгийн томилгоог тодотгон сурган зааварлах хичээл явууллаа.

Ахмад Л.ТҮМЭНДЭЛГЭР



ЦЭРГИЙН ХЭРГИЙН МЭДЛЭГ, УР ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭВ



Баянхонгор аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Тус Цэргийн штабаас 2021 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу цэргийн дүйцүүлэх албаны "Тусгай үүргийн бэлтгэл шатны" сургалтыг хээрийн байрлалд Зэвсэгт хүчний 143 дугаар

тусгай рот, Баянговь сумын ЗДТГ-тай хамтран зохион байгууллаа.

Цэргийн дүйцүүлэх албаны "Тусгай үүргийн бэлтгэл" шатны сургалтаар цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэдтэй аймгийн физик,

газар зүйн онцлог, гамшгийн эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан тусгай тоноглолын техник хэрэгсэл дээр үүрэг гүйцэтгэх дадлага, чадвар эзэмшүүлэх, Батлан хамгаалах хууль тогтоомж, цэргийн хэргийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилтыг тавьж хэрэгжүүлээ.

Сургалтад 2020-2022 онд цэргийн дүйцүүлэх албыг биеэр хааж байгаа алба хаагчид сургалтад бүрэн хамрагдав. Мөн сургалтын явцад Баянговь сумын Цагаан голын гүүр, далангийн нийт 155,7 метр газарт их засварын ажил, эрүүл мэндийн төвийн ашиглалтаас гарсан барилгын нураалтын ажил, төвлөрсөн хойлин цэгийг шороогоор булж далдлах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Хошууч Г.БАТ-ӨЛЗИЙ

Сэрэмжлүүлэг

ГАЗАР ХӨДЛӨЛТ

ГАЗАР ХӨДЛӨЛТӨД УРЬДЧИЛАН ЯАЖ БЭЛТГЭХ ВЭ?

Хүн бүр газар хөдлөлтийн үед гэр орон, ажил дээрээ, олон нийтийн үйлчилгээний газар, нийтийн тээврийн хэрэгсэл, машин дотор байх үедээ юунд анхаарч, ямар арга хэмжээ авах талаар өөрсдөө судлан мэдэж авсан байх нь чухал. Мөн хүн эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх чадварыг эзэмшсэн байвал зохино.

Бичиг баримт, хувцас, хэрэглэл, мөнгө зэрэг болон бусад шаардлагатай зүйлсийг тохиромжтой газарт бэлэн байлгах, гэртээ ус, хүнс, эм, ариутгах, ороох боох материал нөөцөлж, шкаф, шүүгээ зэрэг эд зүйлсийг хананд бэхэлж, өндөр тавиур дээрээс хүнд жинтэй зүйлс унахаас болгоомжлох, цахилгаан, хий, усыг хаах, тухайн нутаг дэвсгэрийн оршин суугчдын цугларах ёстой цэг хаана байдгийг мэдэж авсан байх хэрэгтэй.

Түүнчлэн цахилгаан шатнаас бусад гарч болох аврах гарц, өрөө тасалгаа, хонгилын аюулгүй байрлал, багтаамж зэргийг урьдчилан тодорхойлж, өөрийгөө болон өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, бага насны хүүхдийг эрсдэлээс хамгаалах бүхий л боломжтой талын арга хэмжээг авахад бэлэн байвал зохино.

ГАЗАР ХӨДЛӨХ ҮЕД ХЭРХЭХ ВЭ?

Барилга байгууламжийн чичиргээ, гэрлийн бүрхүүл, хөшиг, бусад зүйлсийн савлах хөдөлгөөн, дуу чимээ, хагарч байгаа цонхны шилийг хараад аль болох айж сандарч болохгүй. Гэвч эхний түлхэлтээс байшин нурах хүртэл 5-20 сек болдог гэдгийг сана!

Бичиг баримт, мөнгө, нэн шаардлагатай хэрэглээний зүйлсээ түргэн авч маш яаралтай байшингаас гарах хэрэгтэй. Цахилгаан шат ашиглаж болохгүй, аваарын шатаар бууж гараад байшин барилгаас хол задгай талбайд яаралтай очих. Ийм үед маш тайван байх хэрэгтэй бөгөөд бусдыг ч тайвшруулах хэрэгтэй.

Байшингаас гарч амжаагүй бол аль болох аюулгүй газар бараадна. Тухайлбал байшингийн дотор хана, булан, даацын хана баганын дэргэд, тэрчлэн ширээн доогуур орж нуугдах хэрэгтэй. Энэ нь дээрээс хүнд юм унаж бэртээж гэмтээхээс хамгаалах магадлалтай. Цонх, хананд өлгөөтэй зүйлс, халаалт дулаан, цахилгааны хэрэгсэл, хүнд тавилга, эд хогшлоос хол байх.

Гэр бүлийнхээ гишүүддээ энэ талаар ухуулан ойлгуулах хэрэгтэй. Хэрвээ байшинд шатах хий алдагдаж байвал гал гаргаж тамхи татах оч үсэргэж болохгүй. Нурсан байшингаас унжсан мод, чулуу, цахилгааны утаснаас хол байна.

Машинд явж байсан бол аюул багатай газар олж зогсоод газар хөдлөлтийн чичирхийлэлд зогсол машинаасаа гарах хэрэггүй. Аль болох өндөр барилгаас хол ил задгай талбай олж зогсохыг хичээнэ. Газар хөдлөлтийн үед хүн бүр хэн нэгэнд тусламж үзүүлэх чадвартай байх шаардлагатай юм.

Өрөө, байшингийн хамгийн аюулгүй газар нь суурь хананы уулзварууд байдаг тул эдгээр ханануудын дор хорогдож болно. Хамгийн тохиромжтой байрлал нь: хөл дээрээ сөхөрч суун биеэрээ урагш тонгойн толгой, нүүрээ гараараа хаах эсвэл нүүрээ хана руу харуулан зогсох, барилгын даацын буюу суурь хананы дагуу доош харан хэвтэх юм. Байшингийн дээвэр дээр гарах, шатны дор болон шатан дээр бөөгнөрөх хэрэггүй. Өрөө тасалгаа, байшингаа орхиж явахдаа цахилгааны болон хийн төхөөрөмжүүдээ унтраана. Нэг давхраас болон дан байшингаас цонхоор гарч болно. Энэ үед

болгоомжтой байхгүй бол хагарсан шилэнд гэмтэж болзошгүй юм.

Хий дамжуулах хоолой гэмтсэн тохиолдолд өрөөнд дэлбэрэх аюул үүсэж болзошгүй тул ил гал гаргахгүй байж, салхи сайн оруулах, аливаа шалтгаанаас гал гарсан үед унтраана. Гэр бүлийн хүмүүс аюулгүй газарт цугларч бага насны хүүхдүүдээ дундаа авч нэг нэгэндээ наалдаж сууна. Гэрлийн эх үүсвэр, аврагч нарт дохио дамжуулах шүгэл зэрэг байх хэрэгтэй ба холбоо харилцаа тасарсан үед гадна орчноос мэдээлэл авч байх өөрөөсөө тэжээлтэй радио хүлээн авагч байлгах хэрэгтэй.

Гудамжинд явах үед нэн даруй өндөр байшин барилга, эд зүйлсээс холдоно. Эвдэрсэн байшингийн дэргэд очихдоо болгоомжтой байх. Учир нь тэнд гэнэт нурулт үүсэж болзошгүй. Дээрээс унах байшингийн хана болон янз бүрийн эд зүйлс, рекламны самбар зэрэгт өртөж гэмтэж, амь насаа алдаж болох тул тал бүрийн сэрэмжтэй байх.

ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ДАРАА ХЭРХЭХ ВЭ?

Сандарч тэвдсэн хүүхэд, өндөр настан, бэртэж гэмтэгсдийг аль болох тайвшруулж, тусламж үзүүлнэ. Гэмтсэн барилгын шатаар буухдаа шатны бат бөх байдал алдагдсан эсэхийг сайтар нягталж үзсэний дараа бууна. Газар хөдлөлтийн дараагийн 2-3 цаг бол маш аюултай, дахин хүчтэй түлхэлт явагдах магадлал өндөр байдаг тул зайлшгүй онцгой чухал хэрэггүй бол байшинд орохгүй байх шаардлагатай.

Хэрэв нурангийн дор орсон бол маш тайван байж орчин тойрноо ажиглаж, сонсоод хүмүүс ойр байвал өөрийнхөө байгаа газрыг мэдэгдэх арга хэмжээ авна. Ингэхийн тулд хашхирах, шүгэлдэх ямар нэг юм нүдэх зэргээр дохио өгч болно. Ийм үед өөрийн тамир тэнхээг дэмий зүйлд зарцуулалгүй маш гамнах хэрэгтэй. Ингэсэн цагт хэрэв ус бий тохиолдолд хүн юу ч идэхгүй, зөвхөн ус ууж хагас сар илүүтэй мэдэж чаддаг байна.

Ийм гамшгийн үед хамгийн элбэг тохиолдох хохирол бол хүмүүс байшин барилгын нуранги, хүнд эд зүйлд дарагдах явдал. Ийм байдалд орсон үед цусан хангамж, бодисын солилцоо алдагдаж, эд эрхтэн гэмтэж хүний сэтгэцэд маш хүнд эмгэг үүсдэг бөгөөд үүнээс болж бодисын солилцооны системд хортой бодис үүсэж хуримтлагдан тэр нь цусанд орох үед хүн амь насаа алдахад хүрдэг байна.

Иймээс аврах ажиллагааны үед анхны тусламж үзүүлж, эмнэлэгт яаралтай хүргэх явдал нэн чухал. Мөн нурангид өртсөн хүнийг үхэлд хүргэх бас нэг гол шалтгаан нь бөөрний дутагдал. Хавчигдаж боогдсон, дарагдсан булчинд хортой бодис болох миоглобины молекулууд үүсдэг ба энэ нь цусаар дамжин бөөрөнд хүрч сүвгүүдийг гэмтээнээр бөөрний дутагдал болж хүний амь нас үрэгддэг байна.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ХШҮГ-ЫН ГАЛ ТҮЙМРИЙН ХЯНАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ, ДЭД ХУРАНДАА С.ЗОРИГТБААТАР

